

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/228/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.mn
Аудитор: Т.Баасанцэнд
Утас: 261628 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 12 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 12 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 13 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 13 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 14 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 16 |
| 4.1 Ерөнхий зүйл | 16 |
| 4.2 Материаллаг байдал | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 16 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 17 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 18 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 19 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ГЕГ | Гаалийн ерөнхий газар |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/338

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 587 дугаар тогтоолоор 258,594.5 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглаж болох 19 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 77,578.4 мянган төгрөгөөр тогтоосныг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь тайлант онд 29092 удаагийн гаалийн бүрдүүлэлт хийж, улсын төсөвт 90,495,580.0 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 80,176,733.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 88.6 хувьтай хэрэгжсэн буюу орлогын төлөвлөгөөг дутуу төвлөрүүлсэн байна.

Тус гаалийн газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гаалийн татварын орлого нь тухайн байгууллагын харилцах дансанд бус гаалийн ерөнхий газрын харилцах дансанд төвлөрч, санхүүгийн тайланд тусгагддаггүйгээс шалтгаалан орлогын тулгалт хийхэд хүндрэлтэй асуудлууд үүсч байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature]
Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 33,639,359.03 | 21,998,049.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 33,639,359.03 | 21,998,049.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 2,588,300.00 | - |
| 35400 | Хангамжийн материал | 31,051,059.03 | 21,998,049.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,967,340.00 | 731,050.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,956,970.03 | 19,240,379.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,631,250.00 | 1,411,250.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,495,499.00 | 615,370.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 562,819,781.73 | 1,566,764,553.19 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 562,819,781.73 | 1,566,764,553.19 |
| 39200 | Биет хөрөнгө | 525,886,510.73 | 1,530,922,657.19 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 146,145,000.00 | 146,145,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (48,542,708.23) | (82,900,208.23) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 926,873,822.76 | 1,951,594,937.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (572,592,930.21) | (547,492,564.51) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 79,229,848.00 | 80,256,220.85 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,226,521.59) | (16,680,728.48) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 36,933,271.00 | 35,841,896.00 |
| 39301 | Програм хангамж | 40,004,021.00 | 40,004,021.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,070,750.00) | (4,162,125.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 596,459,140.76 | 1,588,762,602.19 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 18,996,119.48 | 1,507,884.22 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 18,996,119.48 | 1,507,884.22 |
| 41300 | Өглөг | 18,996,119.48 | 1,507,884.22 |
| 41360 | Бусад өглөг | 18,996,119.48 | 1,507,884.22 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 476,600.00 |
| 41362 | НДШ-ийн өглөг | 1,173,736.09 | - |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 17,822,383.39 | 1,031,284.22 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 577,463,021.28 | 1,587,254,717.97 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 577,463,021.28 | 1,587,254,717.97 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 264,349,638.94 | 264,349,638.94 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 264,349,638.94 | 264,349,638.94 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 278,178,584.34 | 1,322,905,079.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 166,250,188.80 | 313,113,382.34 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 111,928,395.54 | 1,009,791,696.69 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 34,934,798.00 | - |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 596,459,140.76 | 1,588,762,602.19 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 4,091,960,485.96 | 5,194,609,021.15 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 278,995,662.90 | 5,194,609,021.15 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 278,995,662.90 | 1,442,864,112.15 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 70,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 70,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 274,113,662.90 | 1,441,191,562.15 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,882,000.00 | 1,602,550.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 3,751,744,909.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 3,751,744,909.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 3,751,744,909.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 3,751,744,909.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,812,964,823.06 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,742,964,823.06 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,742,964,823.06 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 70,000,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,000,000.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,979,922,090.42 | 4,035,689,677.52 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,979,922,090.42 | 4,035,689,677.52 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,582,104,627.93 | 3,869,371,160.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,895,955,142.04 | 3,055,820,092.80 |
| 210101 | Үндсэн цалин | 1,415,916,850.32 | 1,495,235,879.85 |
| 210102 | Нэмэгдэл | 724,245,384.92 | 719,557,029.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 415,617,000.00 | 498,180,000.00 |
| 210104 | Урамшуулал | 340,175,906.80 | 342,847,183.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 363,384,214.21 | 378,717,679.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 249,425,581.83 | 259,696,421.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 29,306,780.51 | 30,573,020.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 14,749,422.20 | 15,917,508.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 13,980,486.02 | 14,506,145.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 55,921,943.65 | 58,024,583.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,962,368.28 | 82,561,643.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,213,968.28 | 1,675,243.60 |
| 210304 | Байрны түрээс | 19,748,400.00 | 80,886,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,803,375.00 | 37,066,133.03 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,244,410.00 | 11,543,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,290,000.00 | 14,350,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,158,465.00 | 1,075,615.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,110,500.00 | 2,152,840.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 7,944,438.03 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 25,791,050.00 | 5,301,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,854,350.00 | 2,391,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 897,200.00 | 1,658,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,039,500.00 | 1,251,650.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 70,000,000.00 | - |
| 210701 | Гадаад албан томилолт | 70,000,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,126,808.00 | 21,674,918.00 |

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-------------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,433,600.00 | 9,076,552.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,933,740.00 | 2,390,472.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 235,000.00 | 1,578,462.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 63,000.00 | 85,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,887,000.00 | 2,880,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,574,468.00 | 664,432.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 159,081,670.40 | 288,229,143.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 300,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,096,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 150,685,670.40 | 288,229,143.75 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 397,817,462.49 | 166,318,517.02 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 114,184,688.02 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 114,184,688.02 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 114,184,688.02 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 114,184,688.02 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 181,854,822.67 | 52,133,829.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 52,133,829.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 181,854,822.67 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 215,962,639.82 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 215,962,639.82 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 112,038,395.54 | 1,158,919,343.63 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 110,000.00 | 149,127,646.94 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | - | 149,017,646.94 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 110,000.00 | 110,000.00 |
| VII | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (110,000.00) | (149,127,646.94) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 111,928,395.54 | 1,009,791,696.69 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 3,812,964,823.06 | 3,751,744,909.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 3,751,744,909.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 3,751,744,909.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 3,751,744,909.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 3,751,744,909.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 3,751,744,909.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,812,964,823.06 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,742,964,823.06 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,742,964,823.06 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 70,000,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,000,000.00 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,812,964,823.06 | 3,751,744,909.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,812,964,823.06 | 3,751,744,909.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,415,147,360.57 | 3,585,426,391.98 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,866,977,449.79 | 3,059,534,511.60 |
| 210101 | Үндсэн цалин | 1,301,168,338.69 | 1,419,775,175.45 |
| 210102 | Нэмэгдэл | 814,578,210.26 | 780,535,163.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 415,722,156.48 | 514,304,399.39 |
| 210104 | Урамшуулал | 335,508,744.36 | 344,919,773.36 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 372,112,437.50 | 392,685,827.78 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 244,910,000.00 | 248,575,827.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 33,747,437.50 | 60,308,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 24,430,000.00 | 13,966,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 13,805,000.00 | 13,966,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 55,220,000.00 | 55,867,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,962,368.28 | 82,561,643.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,213,968.28 | 1,675,243.60 |
| 210304 | Байрны түрээс | 19,748,400.00 | 80,886,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,763,015.00 | 24,235,005.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,444,050.00 | 7,476,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,400,000.00 | 14,130,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,158,465.00 | 1,075,615.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,760,500.00 | 1,552,840.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,477,750.00 | 2,191,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,962,250.00 | 673,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 792,000.00 | 997,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,723,500.00 | 521,250.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 70,460,000.00 | - |
| 210701 | Гадаад албан томилолт | 70,000,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 460,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 29,998,340.00 | 24,217,754.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,433,600.00 | 9,288,820.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,933,740.00 | 2,390,472.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 235,000.00 | 1,578,462.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 63,000.00 | 85,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,887,000.00 | 2,880,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,446,000.00 | 2,995,000.00 |

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,396,000.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 300,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,096,000.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 397,817,462.49 | 166,318,517.02 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 114,184,688.02 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 114,184,688.02 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 114,184,688.02 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 114,184,688.02 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 181,854,822.67 | 52,133,829.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 181,854,822.67 | 52,133,829.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 215,962,639.82 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 215,962,639.82 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | - | - |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|----------------------|--|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 264,349,638.94 | 34,934,798.00 | 234,064,160.68 | 533,348,597.62 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (67,813,971.88) | (67,813,971.88) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 111,928,395.54 | 111,928,395.54 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 264,349,638.94 | 34,934,798.00 | 278,178,584.34 | 577,463,021.28 |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | -34,934,798.00 | 34,934,798.00 | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,009,791,696.69 | 1,009,791,696.69 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 264,349,638.94 | - | 1,322,905,079.03 | 1,587,254,717.97 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------|--|-------------------------|-------------------------|-----------------------|-------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 3,786,901,200.00 | 3,637,560,220.98 | 149,340,979.02 | 96.1 |
| 12 | Татварын бус орлого | 3,786,901,200.00 | 3,637,560,220.98 | 149,340,979.02 | 96.1 |
| 122 | Тусламжийн орлого | 3,786,901,200.00 | 3,637,560,220.98 | 149,340,979.02 | 96.1 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 3,786,901,200.00 | 3,637,560,220.98 | 149,340,979.02 | 96.1 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,786,901,200.00 | 3,637,560,220.98 | 149,340,979.02 | 96.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,786,901,200.00 | 3,637,560,220.98 | 149,340,979.02 | 96.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,734,629,700.00 | 3,585,426,391.98 | 149,203,308.02 | 96.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,131,107,600.00 | 3,059,534,511.60 | 71,573,088.40 | 97.7 |
| 210101 | Үндсэн цалин | 1,430,008,400.00 | 1,419,775,175.45 | 10,233,224.55 | 99.3 |
| 210102 | Нэмэгдэл | 813,054,100.00 | 780,535,163.40 | 32,518,936.60 | 96.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 543,130,500.00 | 514,304,399.39 | 28,826,100.61 | 94.7 |
| 210104 | Урамшуулал | 344,914,600.00 | 344,919,773.36 | (5,173.3) | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 392,730,900.00 | 392,685,827.78 | 45,072.22 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 248,620,900.00 | 248,575,827.78 | 45,072.22 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 60,308,700.00 | 60,308,700.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,966,900.00 | 13,966,900.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 13,966,900.00 | 13,966,900.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 55,867,500.00 | 55,867,500.00 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 134,483,900.00 | 82,561,643.60 | 51,922,256.40 | 61.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,986,600.00 | 1,675,243.60 | 2,311,356.40 | 42.0 |
| 210304 | Байрны түрээс | 130,497,300.00 | 80,886,400.00 | 49,610,900.00 | 62.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,342,000.00 | 24,235,005.00 | 9,106,995.00 | 72.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,976,400.00 | 7,476,550.00 | 2,499,850.00 | 74.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,150,400.00 | 14,130,000.00 | 20,400.00 | 99.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,246,500.00 | 1,075,615.00 | 170,885.00 | 86.3 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,968,700.00 | 1,552,840.00 | 6,415,860.00 | 19.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,131,700.00 | 2,191,650.00 | 4,940,050.00 | 30.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 763,000.00 | 673,000.00 | 90,000.00 | 88.2 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 997,400.00 | 997,400.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,371,300.00 | 521,250.00 | 4,850,050.00 | 9.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 34,733,600.00 | 24,217,754.00 | 10,515,846.00 | 69.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,030,000.00 | 9,288,820.00 | 2,741,180.00 | 77.2 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,977,100.00 | 5,000,000.00 | 4,977,100.00 | 50.1 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,100.00 | 2,390,472.00 | 109,628.00 | 95.6 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,580,000.00 | 1,578,462.00 | 1,538.00 | 99.9 |

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-----------|---|---------------|---------------|--------------|-------------|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 174,000.00 | 85,000.00 | 89,000.00 | 48.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,880,000.00 | 2,880,000.00 | 2,000,000.00 | 59.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,592,400.00 | 2,995,000.00 | 597,400.00 | 83.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,100,000.00 | - | 1,100,000.00 | 0.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,100,000.00 | - | 1,100,000.00 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,271,500.00 | 52,133,829.00 | 137,671.00 | 99.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 52,271,500.00 | 52,133,829.00 | 137,671.00 | 99.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 52,271,500.00 | 52,133,829.00 | 137,671.00 | 99.7 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 84 | 76 | 8 | 90.5 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 84 | 76 | 8 | 90.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 5 | 5 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 70 | 63 | 7 | 90.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 8 | 1 | 88.9 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын даргын 2002 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 159 дугаар тушаалаар Олон улсын шуудан илгээмж дэх гаалийн газрыг анх байгуулсан ба Гаалийн ерөнхий газрын даргын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/27 тушаалаар Олон улсын шуудан илгээмжийн гаалийн хороог Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар болон өөрчилсөн байна.

Гаалийн газрын эрхэм зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино.

Гаалийн газрын стратеги зорилтууд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах;
- Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх;
- Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус Гаалийн газар нь Авлигын эсрэг хууль, Гаалийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаанд мөрдлөг болгож байна.

Тайлант хугацаанд Гаалийн газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Гадаад тариф, гаалийн татварын тухай хууль;
- Гаалийн улсын байцаагчийн ёс зүй дүрэм
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг баталсан.
- Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын журам

Гаалийн газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шалгагдагч байгууллагад дотоод хяналт хариуцсан ажилтан, дотоод хяналтын нэгж байхгүй бөгөөд Гаалийн ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант хугацаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус гаалийн газар нь Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч шинэчлэгдсэн заавар, журмыг тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 992,303.6 мянган төгрөгөөр буюу 166.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 33,639.3 | 21,998.0 | (11,641.3) |
| Үндсэн хөрөнгө | 562,819.7 | 1,566,764.6 | 1,003,944.9 |
| Нийт хөрөнгө | 596,459.0 | 1,588,762.6 | 992,303.6 |
| Өр төлбөр | 18,996.0 | 1,507.9 | (17,488.1) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 577,463.0 | 1,587,254.7 | 1,009,791.7 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 596,459.0 | 1,588,762.6 | 992,303.6 |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Үүнд:

Бараа материал дансны үлдэгдэл 11,641.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,003,944.9 мянган төгрөгөөр өссөн нь ГЕГ-ын даргын .. тоот тушаалаар 1,361,678.5 мянган төгрөгийн гаалийн хяналт шалгалт хийх рентген тоног төхөөрөмж, алт, үнэт металл сорьц тодорхойлох тандалтын багаж болон хар тамхи мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис илрүүлэгч тандалтын багажыг шилжүүлэн авснаар нэмэгдэж, тайлант үеийн 288,229.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурснаас голлон шалтгаалжээ.

Биет бус хөрөнгөд 16,566.2 мянган төгрөгийн программ хангамж, 23,455.8 мянган төгрөгийн лиценз бүртгэлтэй байна. Эдгээр программын ашиглалтын зардлыг Гаалийн ерөнхий газраас жил бүр сунгалт хийдэг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 17,488.1 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өглөг болон НДШ-ийн өглөг нийт 18,996.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг төлж барагдуулж, жилийн эцэст 1,031.3 мянган төгрөгийн ХХОАТ, 476.6 мянган төгрөгийн байгууллагад өгөх өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн болох 1,009,791.7 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус гаалийн газрын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,026,990.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 1,507,115.7 мянган төгрөгөөр бууруулж 3,519,875.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Энэ нь тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах 628,448.8 мянган төгрөгийг Гаалийн ерөнхий газраас үнэ төлбөргүйгээр олгохоор болсон мөн бичиг хэргийн зардал, шуудан холбооны зардал, архивын өрөөний засварын зардал, албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг болон хөдөлмөр хамгааллийн зардлуудыг хассан байна.

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,519,875.0 мянган төгрөгөөр тооцон баталсан бөгөөд тайлант оны батлагдсан төсвөөс эд хогшил, урсгал засварын зардлаас 3,868.3 мянган төгрөгийг хасч, цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 206,107.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 27,105.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,483.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 4,092.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 19,733.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,100.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 2,271.5 мянган төгрөг, нийт 267,026.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 3,786,901.2 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,786,901.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,751,744.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 3,637,560.2 мянган төгрөг зарцуулж, 114,184.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,637,560.2 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 149,341.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|-------------|-------------|-----------|---------|
| 1 | 70205-Татвар хураалт орлого бүрдүүлэлт | 3,786,901.2 | 3,637,560.2 | 149,341.0 | 96.1 |
| 2 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 3,723,289.7 | 3,576,437.6 | 146,852.1 | 96.1 |
| 3 | 80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 11,340.0 | 8,988.8 | 2,351.2 | 79.3 |
| 4 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 52,271.5 | 52,133.8 | 137.7 | 99.7 |

Тус гаалийн газар нь тайлант онд төрийн албан хаагчдын 9 хувийн орон тооны цомхотголыг хэрэгжүүлээгүй байна. Тухайн орон тооны цомхотголтой холбоотой саналыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн боловч шийдвэр ирүүлээгүй байна.

Хоол унааны хөнгөлөлтийг олгохдоо Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/193 дугаар тушаалын дагуу нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг 30.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Тайлант оны батлагдсан төсөв 543,130.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 514,304.4 мянган төгрөг буюу 28,826.1 мянган төгрөгийн хэмнэлттэй байна.

Гадаад томилолт, арга хэмжээ, сургалт, семинар, хурал, зөвөлгөөнд тус тус зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 135,504.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 харилцагчтай байрны түрээсийн гэрээг 105,504.0 мянган төгрөгөөр байгуулж, багаж техник хэрэгсэл, урсгал засвар, бичиг хэрэг, тээвэр шатахууны зардалд 26,426.6 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дэлгэрмаа, аудитор М.Цэнд-Аюуш нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,980,032.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 39,800.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бичиг хэрэг, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлыг хэмнэн ажилласан байна. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлэх шаардлагатай боловч 2025 онд хичээл үйлдвэрлэлийн зардал, томилолтын зардлыг тэвчих зэрэг арга хэмжээ авч ажилласан ба хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 594,196.3 мянган төгрөгийн зөрчлөөс 426,478.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 167,718.3 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 167,248.7 мянган төгрөгийн 2 удаагийн орлого, 259,229.3 мянган төгрөгийн 2 удаагийн зарлагын мөнгөн гүйлгээг тус тус шилэн дансанд мэдээллээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн 264,349.6 мянган төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 96,631.3 мянган төгрөгөөр тусгагдаж, 167,718.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2-т “Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ”, 8.2.3-т “хувь нийлүүлсэн хөрөнгө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээний төрийн өмчийн дүнд өөрчлөлт оруулж, санхүүгийн тайланд тусгагдсан дүнтэй зөрүүгүй бүртгэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, улсын бүртгэлийн гэрчилгээний төрийн өмчийн дүн нь Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журамтай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татварын бүртгэл, өглөг, авлагын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 237,258.3 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 10,123.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 10,123.0 | 2 | 10,123.0 | 100.0 |
| Нийт дүн | 2 | 10,123.0 | 2 | 10,123.0 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудад дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд гаалийн болон бусад татвар хураамжийг ногдуулах, хураах, тэдгээрт хяналт тавьж, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх ажлын хүрээнд тайлант онд 80,176,733.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 11.4 хувиар тасарсан учир аудитын явцад тус гаалийн газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхтэй холбоотойгоор гаалийн бүрдүүлэлт, ногдуулалт түүний төлөлтийг тулган шалгахад тайлант онд 79,936,458.9 мянган төгрөгийн ногдуулалтад 72,060,273.7 мянган төгрөгийн гаалийн төлбөр төлөгдөж 7,879,185.2 мянган төгрөгийн дутуу төлөлттэй байсан. Гэтэл шалгагдагч байгууллага тайлбар ирүүлэхдээ 79,355,216.4 мянган төгрөгийн орлого банкаар орсон гэсэн тайлбар ирүүлсэн нь эргэлзээтэй бөгөөд эрсдэл бүхий гэж үзсэн;
2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх гаалийн байгууллагуудын татвар хураамжийн орлогууд Гаалийн ерөнхий газрын 5 арилжааны банкны дансанд төвлөрдөг ба үүнээс гаалийн байгууллага бүр өөрт хамаарах орлогын гүйлгээг түүвэрлэн авч тулгалтыг хийдэг. Үүнээс шалтгаалан иргэн, аж ахуйн нэгжид ногдуулсан төлбөр төлөгдсөн эсэхийг хянаж, төлөгдөөгүй мөнгө өөр ямар дансанд орсныг хайж олох замаар нарийн төвөгтэй байдлаар нягтлан бодох бүртгэл хөтлөгдөж байна. Эдгээр орлогууд Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүүгийн тайланд тайлагнагддаггүй, Гаалийн ерөнхий газарт гүйлгээ баланс гаргаж нэгтгэдэг;
3. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:
 - Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
 - Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **293,941.1** мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Залруулсан алдаа: УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалтыг хангаагүй дараах алдааг залрууллаа. Үүнд,

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тодруулга тайлангийн тайлант үеийн элэгдэл дансны дүнгээс 30,710.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардал болох 149,127.6 мянган төгрөгийг тайлагнаагүй, Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд “Үнэ шинэчлэн тогтоосон” 262,168.8 мянган төгрөгийг тайлагнаагүй;
- Цахим татварын системийн татварын тооцооллоор 1,017.3 мянган төгрөгийн татварын өрийн үлдэгдэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд 45.0 мянган төгрөгийн авлагатайгаар тайлагнаж татварын өрийн үлдэгдлийг 1,062.3 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.

Нийт илрүүлсэн залруулагдаагүй алдаа болон зөрчил байхгүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|------------|------------------|-----------------------------------|----------------|--------------------------|------------------|------------|------------------|--------------|----------|----------|----------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тодруулга тайлангийн тайлант үеийн элэгдэл дансны дүнгээс 30,710.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 30,710.0 | - | - | 1 | 30,710.0 | 1 | 30,710.0 | - | - | - | - |
| 2 | Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардал болох 149,127.6 мянган төгрөгийг тайлагнаагүй, Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд “Үнэ шинэчлэн тогтоосон” 262,168.8 мянган төгрөгийг тайлагнаагүй | 1 | 262,168.8 | - | - | 1 | 262,168.8 | 1 | 262,168.8 | - | - | - | - |
| 3 | Цахим татварын системийн татварын тооцооллоор 1,017.3 мянган төгрөгийн татварын өрийн үлдэгдэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд 45.0 мянган төгрөгийн авлагатайгаар тайлагнаж татварын өрийн үлдэгдлийг 1,062.3 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. | 1 | 1,062.3 | 1 | 1,062.3 | - | - | 1 | 1,062.3 | - | - | - | - |
| | Дүн | 3 | 293,941.1 | 1 | 1,062.3 | 2 | 292,878.8 | 3 | 293,941.1 | - | - | - | - |

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|-------------|------------------|-----------------|------------------|-----------------------------------|-----|----------|------------------|
| | | | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 167,248.7 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 259,229.3 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээллээгүй байна. | 1 | 426,478.0 | 1 | 426,478.0 | - | - | - | - |
| | Дүн | 1 | 426,478.0 | 1 | 426,478.0 | - | - | - | - |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн 264,349.6 мянган төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 96,631.3 мянган төгрөгөөр тусгагдаж 167,718.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | 167,718.3 | - | - | - | - | 1 | 167,718.3 |
| | Дүн | 1 | 167,718.3 | - | - | - | - | 1 | 167,718.3 |
| | Нийт дүн | 2 | 594,196.3 | 1 | 426,478.0 | - | - | 1 | 167,718.3 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 319/АД150061

Улаанбаатар хот

САГ - 2026/228/НА - СТА - ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 167,248,680.00 /нэг зуун жаран долоон сая хоёр зуун дөчин найман мянга зургаан зуун наян/ төгрөгийн орлого, 2 удаагийн 259,229,300.00 /хоёр зуун тавин есөн сая хоёр зуун хорин есөн мянга гурван зуун/ төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээллээгүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Батбаяр/, санхүү аж, ахуйн албаны ахлах нягтлан бодогч /Н.Лхагва/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ